

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Буянт-Ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал
ТӨААТҮГ –ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/4/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3.	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8.	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.8.1	Аудитын явцад хийсэн залрууллагын талаарх мэдээлэл	7
2.8.2	Залруулаагүй алдаа зөрчилтэй асуудал	8
2.8.3	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10.	Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга	9
2.11.	Шилэн дансны мэдээлэл	9
2.12.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	9
2.13.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3	Менежментийн захидал.....	10
3.1.	Худалдан авах ажиллагааны талаар:	10
3.2.	Худалдан авалтын анхан шатны баримтын талаар:	11
3.3.	Үндсэн хөрөнгийн тооллогын талаар:	11
3.4	Тооцоололын алдаа	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	13
4.1	Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3	Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	17
5	Зорилтод түвшний биелэлт	19
6	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БУЯНТ-УХАА ДАХЬ ЧИНГИС ХААН
ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДЛЫН
ЗАХИРАЛ Д.МӨНХБААТАР ТАНАА

2019.03.15 № 06/457
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буюнт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Буюнт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Буюнт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудлын захирал Д.Мөнхбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Эф Эл Эй Эс Эйч Аудит ХХК-ийн аудитор Б.Баяндүүрэн, аудиторов туслах Г.Цэнд-Аюуш нар хариуцаж хэрэгжүүлэв.

Буянт-Ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланг “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д 2019 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн 09/а/204 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Тус байгууллага нь “Нисэх буудлын үйл ажиллагааг аюулгүй, шуурхай, соёлтой, үр ашигтай зохион байгуулж үйлчлүүлэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц үйлчилгээг бүрдүүлсэн үндэсний шилдэг байгууллага болно.” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Тус байгууллага нь Иргэний нисэхийн дүрэм -139, 140-ийн дагуу аэродром, аюулгүй байдлын үйлчилгээ явуулахаар гэрчилгээ авсан бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байна. Үүнд:

- Нисэхийн аюулгүй байдал, харуул хамгаалалтын үйлчилгээ
- Аэродром ашиглалт
- Зорчигч үйлчилгээ
- Агаарын шуудангийн үйлчилгээ
- Авран туслах, гал унтраах ажиллагаа
- Инженер техникийн үйлчилгээ

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Улсын нисэхийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын санхүү нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Veritech ERP" програм хангамж ашигладаг байна.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын

гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр ТӨААТҮГ тул орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгов.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын дүн 33,411.4 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 334.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь гүйцэтгэлийн үе шатанд эрсдэлийн түвшинг дундаж гэж үнэлсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 17 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 11 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

2.8.1 Аудитын явцад хийсэн залрууллагын талаарх мэдээлэл

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах асуудлыг залруулан санхүүгийн тайланд тусгаж Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав.

- Газар эзэмших эрхийн 000439479 тоот гэрчилгээ нь Иргэний нисэхийн ерөнхий газрын нэр дээр байгаа тул 5207964 м² /га газрыг дахин үнэлж газрын сайжруулалт хэсэгт бүртгэснийг залруулсан.
- Дахин үнэлгээний нэмэгдэл болох 18,136.4 сая төгрөгийг бүртгэлд тусгахдаа ангилал буруу илэрхийлснийг залруулсан.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

2.8.2 Залруулаагүй алдаа зөрчилтэй асуудал

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(сая төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	229.4	
2	Албан шаардлага	1	73.5	
	Дүн	5	302.9	

2.8.3 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Шүүхийн шийдвэрийн дагуу цалингийн маргаанаас үүссэн ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 70.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлбөрт 2.9 сая төгрөг, тэмдэгтийн хураамжид 0.4 сая төгрөгийг төлж үйл ажиллагааны үр дүнг бууруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй. Албан шаардлага хүргүүлсэн.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тус байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан өөрийн хөрөнгийн дүн 5,533.1 сая төгрөг байгаа боловч энэ нь санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн хэсэгт тусгагдаагүй орхигдсон асуудлыг анхаарах шаардлагатай.

Иргэний нисэхийн ерөнхий газраас 50.0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй худалдан авалтыг зохион байгуулдаг бөгөөд зоогийн газар, ресторанд хэрэглэгдэх махны худалдан авалтыг Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын буудал нь өөрсдөө зохион байгуулж худалдан авалтын харьцуулалтын аргыг сонгож байгааг анхаарч үзэх шаардлагатай.

Шүүхийн шийдвэрийн дагуу тэтгэмжийн нөхөн төлбөрт 41.3 сая төгрөг, цалингийн маргаанаас үүссэн ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 70.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлбөрт 2.9 сая төгрөг, тэмдэгтийн хураамжид 0.4 сая төгрөгийг төлж үйл ажиллагааны үр дүнг бууруулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д “Төрийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх” гэж заасныг мөрдөж ажиллаагүй.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар тодруулга

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ нь тайлант хугацааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулж хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд үндсэн ба туслах үйл ажиллагааны орлогыг 27,854.7 сая төгрөг, нийт урсгал зардал 22,608.4 сая төгрөг байхаар баталсан. Нийт орлого 33,411.4 сая төгрөг байгаа нь 120 хувийн биелэлттэй байна. Энэ нь тайлант хугацаанд нислэгийн тоо болон зорчигчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой.

Нийт зардал гүйцэтгэлээр 21,806.3 сая төгрөг байгаа нь 96.4 хувийн биелэлттэй байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Буянт-Ухаа дахь Чингис хаан Олон улсын нисэх буудал ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага тайлант жил 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 690 ширхэг гүйлгээ, зардлын 185 ширхэг гүйлгээг хуулийн хугацаанд мэдээлсэн байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар Капитал банкин дахь харилцах дансны гүйлгээтэй холбоотой маргаантай асуудлыг шийдвэрлэх, авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах талаар 2 зөвлөмж өгөгдсөн нь биелэлт 85 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Худалдан авах ажиллагааны талаар:

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацаанд Ентес ХХК-иас ажилчдын өвлийн нормын хувцас худалдах, худалдан авах гэрээний дагуу урьдчилгаа төлбөрт 29.6 сая төгрөгийг шилжүүлсэн боловч гэрээний биелэлтийг хангаж ажиллаагүйгээс он дамжсан авлага үүсгэж ажилтнуудын хөдөлмөр хамгааллын нормын хувцсыг хугацаанд нь тавьж олгоогүй, гэрээний холбогдох заалт болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг батламж мэдэгдэл зөрчигдөх, авлага, өглөгийн тооцоо үүсэх, ажилтнуудын хөдөлмөр хамгааллын хувцсыг тавьж олгоогүйгээс хөдөлмөр хамгаалал, ажиллах нөхцөлтэй холбоотой эрсдэл үүсэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

“Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдаж авах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Худалдан авах ажиллагаанд

ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэж заасныг баримталж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллана.

3.2. Худалдан авалтын анхан шатны баримтын талаар:

3.2.1 Илрүүлэлт:

Нэр бүхий 9 компаниас 151.7 сая төгрөгийн худалдан авалт хийхдээ НХмаягт ТМ-5 төлбөрийн баримтыг аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл:

Иж бүрэн байх батламж мэдэгдэл зөрчигдөх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалт, Татварын ерөнхий хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхгүй байх. Татварын хяналт шалгалтаар алданги, торгууль хүлээх.

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Бэлтгэн нийлүүлэгчдээс Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан НХМаягт ТМ-5 төлбөрийн баримтыг цаасан болон цахим хэлбэрээр авч байх, алдаа зөрчлийг дахин гаргахгүй байх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллана.

3.3. Үндсэн хөрөнгийн тооллогын талаар:

3.3.1 Илрүүлэлт:

Тус байгууллагад 2014 онд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан албан тушаалтан өөрийн хэрэгцээнд ашиглаж байсан 6.7 сая төгрөгийн үнэ бүхий Ipad Air 16gb, зөөврийн компьютер Mac pro I 7 зэргийг хүлээж аваагүйгээс жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор дутсан байна. 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар албан шаардлага өгсөн нь шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд Хөрөнгө өр төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ, 12.2.1-д “Жилийн санхүүгийн тайлан гарахын өмнө” 12.2-д “Эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой ажилтан солигдох үед хийнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

3.3.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчих, хөрөнгийн дутагдал, шамшигдал үүсэх

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Тухайн хөрөнгийг хүлээн авах буюу зах зээлийн үнээр төлүүлэх

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллана.

3.4 Тооцооллын алдаа

3.4.1 Илрүүлэлт:

2015-2017 онд тус байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нэр бүхий 5 ажилтанд хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох тэтгэмжийг дутуу бодож олгосноос тайлант хугацаанд 41,3 сая төгрөгний тэтгэмжийн зөрүүг нөхөн олгосон байна. Энэ нь хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

3.4.2 Эрсдэл:

Эрх ба үүрэг, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчих, тухайн тайлант онд тэтгэмжийн зардал хэтрэх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Тэтгэмж олголт, түүнтэй холбоотой асуудлыг хуулийн хүрээнд үнэн зөв удирдах, Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтууд, хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Аудитаар гарсан алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн. Зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 7 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017.12.31	2018.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,975,888,182.38	3,072,881,614.07
1.1.2	Дансны авлага	12,808,069,224.88	12,701,862,135.33
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	47,635,247.50	1,980,107.39
1.1.4	Бусад авлага	161,754,137.51	4,727,764,649.85
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	782,749,851.90	576,070,733.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	146,330,000.00	58,886,590.91
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547,500.00	
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
1.1.10			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	19,927,974,144.17	21,139,445,830.64
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	46,213,949,046.79	58,991,030,420.39
1.2.2	Биет бус хөрөнгө	97,618,798.30	56,882,818.98
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	187,996,756.06	238,686,721.73
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,499,564,601.15	59,286,599,961.10
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	66,427,538,745.32	80,426,045,791.74
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	46,350,853.07	8,631,829.58
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	28,232,530.90	333,649,912.05
2.1.1.4	НДШ–ийн өглөг	866,224.30	
2.1.1.5	Богино хугацаат зээл		
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	50,557,447.88	30,360,162.43
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	136,639,416.35	75,336,991.69
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
2.1.1.12	системийн өглөг	7,970,557,357.39	
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,233,203,829.89	447,978,895.75
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			

	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	8,233,203,829.89	447,978,895.75
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.2	- хувийн		
2.3.3	- хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		18,136,422,122.15
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	58,194,334,915.43	61,690,346,842.84
2.3.10	Хойшлогдсон орлого		151,297,931.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	58,194,334,915.43	79,978,066,895.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	66,427,538,745.32	80,426,045,791.74

4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	26,895,302,083.00	29,394,830,389.53
2	Борлуулалтын өртөг	3,045,160,097.39	22,446,610,507.90
3	Нийт ашиг(алдагдал)	3,850,141,985.61	6,948,219,881.63
4	Түрээсийн орлого	1,943,633,738.68	1,930,214,158.87
5	Хүүгийн орлого	273,874,808.21	247,921,580.23
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	1,849,717,206.26	1,454,340,909.37
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,444,429,959.67	1,508,125,389.22
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,635,928,756.69	4,424,919,130.88
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-34,856,874.10	384,038,481.94
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	4,802,152,148.30	5,031,690,491.94
19	Орлогын татварын зардал	690,772,542.38	1,528,938,895.73
20	Татварын дараах ашиг (алдагдал)	4,111,379,605.92	3,502,751,596.21
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	4,111,379,605.92	3,502,751,596.21
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	4,111,379,605.92	3,502,751,596.21
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл			54,082,955,309.51	54,082,955,309.51
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
3	Залруулсан үлдэгдэл			54,082,955,309.51	54,082,955,309.51
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			4,111,379,605.92	4,111,379,605.92
5	Бусад дэлгэрэнгүй орлого				-
6	Өмчид гарсан өөрчлөлт				-
7	Зарласан ногдол ашиг				-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2017 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл			58,194,334,915.43	58,194,334,915.43
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-6,739,668.80	-6,739,668.80
11	Залруулсан үлдэгдэл			58,187,595,246.63	58,187,595,246.63
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			3,502,751,596.21	3,502,751,596.21
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт		151,297,931.00		151,297,931.00
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	18,136,422,122.15			18,136,422,122.15
17	2018 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	18,136,422,122.15	151,297,931.00	61,690,346,842.84	79,978,066,895.99

4.4 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	33,326,279,956.54	36,795,965,863.22
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	29,448,076,467.81	33,611,917,422.82
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	3,878,203,488.73	3,184,048,440.40
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	29,887,044,003.80	39,574,940,320.40
1.2.1	Ажиллагчдад төлсөн	14,105,111,986.03	12,974,633,776.74
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,102,530,520.00	3,567,751,213.44
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	9,341,290,877.95	12,657,303,677.46
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	496,859,152.82	915,211,197.68
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,656,000.00	29,848,140.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,514,907,133.94	4,384,346,303.29
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	308,688,333.06	5,045,846,011.79
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,439,235,952.74	-2,778,974,457.18
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	256,417,273.97	265,379,114.47
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	256,417,273.97	265,379,114.47
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	197,972,375.00	389,411,225.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	189,413,375.00	389,411,225.60
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	8,559,000.00	
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			

2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	58,444,898.97	- 124,032,111.13
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	3,497,680,851.71	-2,903,006,568.31
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,478,207,330.67	5,975,888,182.38
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,975,888,182.38	3,072,881,614.07

5 Зорилтод түвшний биелэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт (хэмнэлт)	
			тоо	хувь
УРСГАЛ ЗАРДАЛ	22,608,445,600.00	21,806,314,624.79	-802,130,975.21	96.5%
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,927,693,700.00	20,127,308,164.32	-800,385,535.68	96.2%
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	14,899,747,600.00	14,423,766,083.88	-475,981,516.12	96.8%
Үндсэн ба нэмэгдэл цалин	12,786,179,000.00	12,332,312,351.52	-453,866,648.48	96.5%
Унаа хоолны хөнгөлөлт	1,474,406,000.00	1,532,964,400.00	58,558,400.00	104.0%
Гэрээт ажлын цалин	639,162,600.00	558,489,332.36	-80,673,267.64	87.4%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,930,607,600.00	1,883,715,110.06	-46,892,489.94	97.6%
Тэтгэврийн даатгал	1,188,066,009.72	1,163,488,457.44	-24,577,552.28	97.9%
Тэтгэмжийн даатгал	148,508,298.96	145,481,365.42	-3,026,933.54	98.0%
ҮОМШӨ-ний даатгал	267,314,823.54	259,314,683.09	-8,000,140.45	97.0%
Ажилгүйдлийн даатгал	29,701,965.35	28,675,510.66	-1,026,454.69	96.5%
Эрүүл мэндийн даатгал	297,016,502.43	286,755,093.45	-10,261,408.98	96.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	910,332,900.00	823,201,034.10	-87,131,865.90	90.4%
Гэрэл, цахилгаан	625,000,000.00	555,312,429.43	-69,687,570.57	88.8%
Түлш, халаалт	182,964,000.00	195,511,684.60	12,547,684.60	106.9%
Цэвэр, бохир ус	102,368,900.00	72,376,920.07	-29,991,979.93	70.7%
Хангамж, бараа материалын зардал	858,440,000.00	767,363,591.20	-91,076,408.80	89.4%
Бичиг хэрэг	59,750,000.00	59,745,278.86	-4,721.14	100.0%
Тээвэр, шатахуун	461,336,000.00	388,604,829.49	-72,731,170.51	84.2%
Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	78,000,000.00	63,800,766.84	-14,199,233.16	81.8%
Хог хаягдал зайлуулах, цэвэрлэгээний зардал	226,354,000.00	222,431,446.68	-3,922,553.32	98.3%
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,000,000.00	32,781,269.33	-218,730.67	99.3%
Нормативт зардал	259,220,700.00	122,677,415.77	-136,543,284.23	47.3%
Нормын хувцас, зөөлөн эдлэл	259,220,700.00	122,677,415.77	-136,543,284.23	47.3%
Эд, хогшил, урсгал засварын зардал	826,884,900.00	870,549,823.44	43,664,923.44	105.3%
Багаж, техник хэрэгсэл	781,884,900.00	811,235,588.01	29,350,688.01	103.8%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	45,000,000.00	59,314,235.43	14,314,235.43	131.8%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	547,791,200.00	538,246,306.47	-9,544,893.53	98.3%
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	54,439,200.00	47,238,027.28	-7,201,172.72	86.8%
Мэдээлэл технологийн үйлчилгээ	11,000,000.00	10,076,791.82	-923,208.18	91.6%

Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Газрын төлбөр	428,404,600.00	424,090,571.70	-4,314,028.30	99.0%
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,900,000.00	13,756,580.79	2,856,580.79	126.2%
Улсын мэдээллийн маягт хэвлэх	43,047,400.00	43,084,334.88	36,934.88	100.1%
Бараа үйлчилгээний бусад зардал	694,668,800.00	697,788,799.40	3,119,999.40	100.4%
Бараа үйлчилгээний бусад зардал	20,000,000.00	20,063,115.89	63,115.89	100.3%
Түүхий эдийн зардал	674,668,800.00	677,725,683.51	3,056,883.51	100.5%
Мэдээлэл сурталчилгааны зардал	36,721,000.00	36,711,816.08	-9,183.92	100.0%
Харуул хамгаалалтын зардал	48,320,000.00	48,223,523.94	-96,476.06	99.8%
Холбооны суваг ашигласны хөлс	193,644,000.00	194,632,341.75	988,341.75	100.5%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	525,295,500.00	525,995,766.24	700,266.24	100.1%
Биеийн тамирын уралдаан, тэмцээн	6,000,000.00	8,975,966.15	2,975,966.15	149.6%
Сургалт семинар	8,000,000.00	7,935,236.27	-64,763.73	99.2%
Дотоод сургалт	8,000,000.00	7,935,236.27	-64,763.73	99.2%
Сургалт семинар зохион байгуулах		3,013,549.77	3,013,549.77	
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	854,447,400.00	843,215,556.26	-11,231,843.74	98.7%
Нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг	220,000,000.00	203,805,154.37	-16,194,845.63	92.6%
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	578,100,400.00	576,543,642.58	-1,556,757.42	99.7%
Шагнал урамшуулал, баяр ёслол	56,347,000.00	62,866,759.31	6,519,759.31	111.6%
Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээ		2,361,000.00	2,361,000.00	
Олон улсын гишүүний төлбөр	8,324,000.00	7,941,704.01	-382,295.99	95.4%
			-	
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	27,854,731,000.00	33,477,570,682.90	5,622,839,682.90	120.2%
Буулт, хөөрөлтийн орлого	10,443,326,100.00	11,368,816,405.70	925,490,305.70	108.9%
Зорчигч үйлчилгээний орлого	11,060,880,000.00	12,159,824,295.50	1,098,944,295.50	109.9%
Бусад орлого	6,350,524,900.00	9,948,929,981.70	3,598,405,081.70	156.7%

6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2019.03.15	Аудитын нэр: Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодрууллагад хийсэн аудит	Аудитын код: САГ-2019/4/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Буянт-Ухаа дахь Чингис хаан олон улсын нисэх буудал	Сая төгрөгөөр	

№	Аудитын чиглэл	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
					Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7
1	Зардлын данстай холбоотой асуудал	Худалдан авалтын анхан шатны баримтын бүрдэлт дутуу	151.8	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Халиунбигэр
2	Зардлын данстай холбоотой асуудал	Шүүхийн шийдвэрийн дагуу, үндэслэлгүй ажлаас халсан шалтгааны улмаас ажиллаагүй хугацааны цалин хөлс 70.1 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн нөхөн төлбөрт 2.9 сая төгрөг, тэмдэгтийн хураамжид 0.4 сая төгрөгийг байгууллагаас төлж үйл ажиллагааны үр дүнг бууруулсан байна.	73.5	Албан шаардлага	Захирал	Д.Мөнхбаатар
3	Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт	Ентес ХХК-тай ажилчдын өвлийн хувцас нийлүүлэх гэрээ хийгдэж урьдчилгаа төлбөр хийгдсэн өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор гүйцэтгэл хийгдэх нөхцөлтэй байсан боловч гэрээний үүргийг	29.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Халиунбигэр

		биелүүлээгүй авлага үүсгэсэн байна				
4	Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн	Ажлаас гарсан хүмүүсээс албан хэрэгцээндээ ашиглаж байсан хөрөнгийг хүлээж аваагүйгээс үндсэн хөрөнгө тооллогоор дутагдсан	6.7	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Халиунбигэр
5.	Тооцооллын алдаа	2015-2017 онд тус байгууллагаас өндөр насны тэтгэвэрт гарсан нэр бүхий 5 ажилтанд хөдөлмөрийн дотоод журмын дагуу олгох тэтгэмжийг дутуу бодож олгосноос тайлант хугацаанд 41.3 сая төгрөгний тэтгэмжийн зөрүүг нөхөн олгосон байна. Энэ нь хөдөлмөрийн дотоод журмын холбогдох заалтыг мөрдөж ажиллаагүй байна.	41,3	Зөвлөмж өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Г.Халиунбигэр
Нийт дүн			302.9			

